

АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Ахуйн үйлчилгээ нь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй болохын зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх өргөн боломжийг бүрдүүлдэг. Монгол Улсад ахуйн үйлчилгээ төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үеэс томоохон салбар болон эрчимтэй хөгжиж ирсэн түүхтэй.

Ахуйн үйлчилгээг хөгжүүлэхэд учирч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд аж ахуйн нэгж, салбар, төрийн бодлогын түвшинд хийгдэх ажлыг тус тус тодорхойлон боломжоо зөв хуваарилан богино хугацаанд шинэчилсэн өөрчлөлтийг хийж салбар хоорондын уялдааг нэмэгдүүлэн ажиллах нь чухал байна.

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8919¹ аж ахуйн нэгж, иргэн бүртгэлтэй байна. Эдгээрийн 8.4 хувь нь нийтийн халуун ус, 24.9 хувь нь үсчин, гоо сайхан, 20.7 хувь нь хувцас захиалга, засвар, 7.4 хувь нь гэрэл зураг авах, угаах, 1.5 хувь нь хими цэвэрлэгээ, 3.2 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 9.3 хувь нь гутал захиалга, засвар, 11.6 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 2.2 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 11.0 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.48.10 дахь заалтад Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэхээр заасны дагуу хөтөлбөрийг 2019-2023 оныг дуустал хэрэгжүүлэхээр тооцоолж байна.

2014 онд батлагдсан “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр” нь 2014-2016 оны хооронд амжилттай хэрэгжиж дууссан. Тус хөтөлбөрийн хүрээнд 6353 сая төгрөгөөр 21 аймгийн хэмжээнд 67 суманд “Ахуйн үйлчилгээний төв” шинээр бий болж 66 сумын барилгыг засварлан шинэчилж үйл ажиллагаа эрхлэх тав тухтай орчинг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх нэгдсэн төвтэй болсон байна

Манай Улсын 21 аймгийн хэмжээнд нийт 164 сумын ахуйн үйлчилгээний төвд хөрөнгө оруулалт хийж, өнөөдрийн байдлаар нийт 231 төв үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд 3444 ажлын байр шинээр бий болсон байна.

Монгол Улсын нийт хүн ам 2016 онд 3,119,935 болж өмнөх оноос 2.03 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан ба энэ нь иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ахуйн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, салбарт ажиллагсдын ажлын байрны нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор ахуйн үйлчилгээний төвийг шинээр болон шинэчлэн бий болгож, салбарын хүний нөөцийг чадавхжуулж, ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишгийн дагуу сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Энэхүү зорилгыг дараах зорилтоор хэрэгжүүлнэ:

2.2.1. Ахуйн үйлчилгээний салбарын эрх зүйн орчинг үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

2.2.2. Ахуйн үйлчилгээний төвүүдийг улсын, орон нутгийн төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулах, засварлах;

¹ Эх сурвалж: ХХААХҮЯам

2.2.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болгосон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

2.2.4. Ахуйн үйлчилгээний салбарын хүний нөөцийг бэлтгэх, **давтан сургаж мэргэшил дээшлүүлэх** тогтолцоог бүрдүүлж, ажиллагсдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Ахуйн үйлчилгээний салбарын эрх зүйн орчинг үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

3.1.1. Ахуйн үйлчилгээний салбарын ангилал, нэр төрлийг олон улсын жишиг, хөгжилд нийцүүлэн тодорхойлно.

3.1.2. Салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж сайжруулах;

3.1.3. Ахуйн үйлчилгээний ангилал тус бүрээр мөрдөгдөх стандартыг олон улсын стандарттай уялдуулан шинээр болон шинэчлэн боловсруулж, хэвшүүлэх

3.1.4. “Мастер ажилтан цол” олгох журмын төслийг боловсруулан батлуулах

3.2. Ахуйн үйлчилгээний төвүүдийг бий болгох замаар ахуйн үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. Орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ахуйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.2.2. Ахуйн үйлчилгээний төвийн зориулалтаар ашиглаж болох нийслэл, орон нутгийн өмчийг засварлаж шинээр ахуйн үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бий болгох;

3.2.3. Аймаг, нийслэлийн хэмжээнд “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг батлуулан, хэрэгжүүлэх

3.2.4. Төвөөс алслагдсан сум, дүүргүүдэд явуулын ахуйн үйлчилгээний хэлбэрийг зохион байгуулах;

3.2.5. Хувийн өмчийн байрыг ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх

3.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болгосон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамруулах;

3.3.2. Тогтвортой үйл ажиллагаа явуулж буй ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ /лизинг/-нд хамруулах;

3.3.3. Хувийн хэвшилд бүтээмж нэмэгдүүлэх, инноваци, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, сайн туршлагыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.4. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бизнес, менежментийн зөвлөх үйлчилгээ, сургалтад хамруулах;

3.4. Ахуйн үйлчилгээний салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлж, ажиллагсдын тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. Ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг үе шаттайгаар;

3.4.2. Салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч үйлчилгээний ёс зүй, ур чадвар, мэргэжлийн сургалтаар нарийн мэргэжлийн ажилчин сургаж бэлтгэх, сургалт зохион байгуулах;

3.4.3. Ахуйн үйлчилгээний чиглэлээр олон улсын өндөр зэрэглэлийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, **олон нийтэд сурталчлах**;

3.4.4. Салбарын мэргэжлийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулах;

3.4.5. Ахуйн үйлчилгээний чиглэлээр олон улсын өндөр зэрэглэлийн уралдаан, тэмцээнд оролцох хүний нөөцийг бэлтгэн сургах;

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа, хамрах хүрээ

4.1. Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хамрах хүрээ: Монгол Улсын Нийслэл, 9 дүүрэг, 21 аймаг, 330 сум

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь:

5.1.1. Төрийн байгууллага;

5.1.2. Төрийн бус байгууллага;

5.1.3. Олон улсын байгууллага;

5.1.4. Аж ахуйн нэгж, иргэд байна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

6.1.1. Улсын төсөв, олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.1.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

6.1.3. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Долоо. Удирдлага, зохион байгуулалт

7.1. Ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан ажлыг эрхэлнэ:

7.1.1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч, оролцогч байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахын зэрэгцээ хэрэгжилтэд нь хяналт, шинжилгээ хийж дүгнэлт өгнө.

7.1.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын зохицуулалтыг бий болгон ажиллана.

7.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд төрийн бус байгууллагыг оролцоог нэмэгдүүлэхээр зохион байгуулалт хийнэ.

7.1.4. Хөтөлбөрийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангана.

7.1.5. Ахуйн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааны жишиг стандарт, журмыг тухай бүр боловсруулж мөрдүүлнэ.

7.1.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулсан улсын төсөв, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө болон гадаадын хандивлагчдаас олгосон хөрөнгө, зээл тусламжийг орон нутагт хуваарилах, хөрөнгө, нөөцийг үр ашигтай зохион байгуулна.

7.1.7. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг жил тутам гарган Засгийн газарт танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

7.1.8. Ахуйн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжид хяналт хяналт тавих, санал боловсруулж шийдвэрлүүлэх асуудлыг нийслэл, орон нутагт аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар гүйцэтгэнэ.

7.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга

7.2.1. Хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийг жил бүр батлан хэрэгжүүлнэ.

7.2.2. Хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

7.2.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн орон нутгийн тайланг хэлэлцэн дүгнэж, хагас болон бүтэн жилээр гарган ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

7.2.4. Орон нутгийн өмчит ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглаж болох барилгыг иргэдэд ашиглуулах ажлыг зохион байгуулах;

7.2.5. Ахуйн үйлчилгээг дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

7.2.6. Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэндийг хохироох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

- 9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг жил бүр Ахуйн үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийж гүйцэтгэнэ.
- 9.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг бүх шатны байгууллагууд Хүнс, хөдөө аж ахуйн газарт, Хүнс хөдөө аж ахуйн газар нь тухайн нийслэл, аймгийн газар нэгтгэсэн тайланг хагас жилийн эхний 7 хоногт Ахуйн үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага яаманд хүргүүлнэ.
- 9.3. Ахуйн үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж Засгийн газарт танилцуулна.
- 9.4. Ахуйн үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа үр дүнгийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулна.
- 9.5. Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 9.6. Үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болно.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2017 он	Зорилтот түвшин 2023 он
1	Салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн тоо	тоо	8,919	10,000
2	Ахуйн үйлчилгээний салбарын ажилтны тоо /шинээр бий болгох ажлын байр/	тоо	22,000	27,000
3	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ахуйн үйлчилгээний цэг	тоо	231	262
4	Сургалт, семинарт хамрагдсан ахуйн үйлчилгээ эрхлэгчийн тоо	тоо	-	2100